



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Төрийн өмчийн хөрөнгийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61.1.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтооюур баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 23 дугаар хороонд байрлах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д бүртгэлтэй “Алтандорнод Монгол” ХХК-аас улсын төсвийн татварын өрөнд хураан авсан хавсралтад заасан ашиглагдахгүй байгаа хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах ажлыг 2024 онд багтаан шуурхай зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан хөрөнгө худалдан борлуулсны орлогыг Дархан-Уул аймагт шилжин байрлах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа Засгийн газрын агентлаг, улсын төсвийн байгууллага, төрийн өмчит компанийн албан хаагчдад зориулсан албан хэрэгцээний орон сууцыг худалдан авахад зарцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Дархан-Уул аймагт шилжин ажиллах албан хаагчдыг орон сууцны орон нутгийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох журамд өөрчлөлт оруулж, эх үүсвэрийг нэмэгдүүлж ажиллахыг Монголбанк (Б.Лхагвасүрэн)-нд зөвлөж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьяд даалгаж, орон нутгийн ипотекийн зээлийн хүүгийн төлбөрт 3 хувийн дэмжлэг үзүүлэх асуудлыг судалж, зохих арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтийг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулан ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР

ШТА1206 3023700394 5498449

Засгийн газрын 2024 оны 10 дугаар
сарын 30-ны өдрийн 152 дугаар
тогтоолын хавсралт

ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үл хөдлөх хөрөнгө	Байршил	Үнэлгээ /төгрөгөөр/
“Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК-д бүртгэлтэй хөрөнгө			
1.	<p>Үйлдвэрлэлийн бааз</p> <p>(1) Нийтийн орон сууцны барилга 7, (2) Цайны газар, үйлчилгээний барилга, (3) Ажилчдын цайны газар 2, (4) Харуулын барилга 2, (5) Даргын конторын барилга, (6) Санхүүгийн конторын барилга, (7) Гүйцэтгэгч байгууллагын конторын барилга, (8) Монгол ажилчдын байр 2, (9) Орос ажилчдын байр, (10) Саун, халуун ус, (11) Даргын сууц, (12) Зуухны байр, (13) Угаалгын газар, (14) Гагнуурын цех, (15) Засварын цех 2, (16) Ажлын байр, (17) Ажилчдын байр 2, (18) Төв агуулах, (19) Ногоон зоорь болон эдгээр объект байрлаж байгаа (20) Улсын бүртгэлийн Э-2201064950 дугаартай 125,183 м² талбайтай, (21) Улсын бүртгэлийн Э-2201064942 дугаартай 689,739 м² талбайтай газар эзэмших эрх</p>	<p>Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах</p>	17,569,869,900
2.	<p>Нефть бүтээгдэхүүний агуулах</p> <p>(1) Харуулын барилга, (2) Аваарын дизель станц, (3) Аваарын дизель станцын вагончик, (4) Операторын барилга, (5) Машины шатахуун буулгах, ачих эстакад, (6) Савласан тос хадгалах агуулах, (7) Галын усны сав 400 м³, (8) Сэлбэг материалын склад, (9) Засварын газрын барилга, (10) Ажилчдын хувцасны барилга, (11) Маслын агуулах, (12) Галын хөөсний сав, (13) Худгийн гаднах барилга, (14) Тунадас цуглуулах сав, байгууламжтай, (15) Насос станцын барилга, (16) Цэвэрлэх байгууламжийн барилга, (17) Контор, үйлчилгээний барилга, (18) Сав 1000 м³, (19) Сав 700 м³ болон эдгээр объект байрлаж байгаа (20) Улсын бүртгэлийн Э-2206012992 дугаартай 21,988 м² талбайтай, (21) Улсын бүртгэлийн Э-2206012993 дугаартай 2,398 м² талбайтай газар эзэмших эрх</p>	<p>Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах</p>	11,555,157,000

	Контор, үйлчилгээний барилга (1) Нийтийн орон сууцны барилга, (2) Конторын барилга, (3) Ажилчдын хоолны газрын барилга, (4) Цахилгаан цех, (5) Бараа материалын агуулах 20-27 тоот хаалга, (6) Хүйтэн агуулах, (7) Засварын цех яамтай-4, (8) Дулаантай агуулах 1-10 хаалга-УХБ агуулах, (9) Дулааны узель (10) Халуун ус сауны барилга, (11) Бассейн, (12) Угаалгын газар том машин, (13) Угаалгын газар жижиг машин, (14) Граж 1, 2, 3 (15) Склад, (16) Баяжуулах цехийн барилга, (17) Хүнсний агуулах, (18) Талхны цех, (19) Мужаан цех, (20) Хүнд техникийн агуулах, (21) Харуулын байр, (22) Компрессорын барилга, (23) 2 хаалгатай агуулах, (24) Агуулах, цехийн барилга, (25) Дарханы цех, дугуй засвар болон эдгээр обьект байрлаж байгаа (26) Улсын бүртгэлийн Э-2206014495 дугаартай 37,870 м ² талбайтай газар эзэмших эрх	Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах	28,048,276,800
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эзэмшлийн хөрөнгө			
1.	Агуулахын барилга, байгууламж Улсын бүртгэлийн 000001841 дугаартай 8190 м.кв талбайтай агуулах	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Баатархайрханы гудамж, 73/2 хаягт байрлах	84,357,000 төгрөгийн балансын үнэтэй

----оо----